

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 221 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам”, Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд 1949 оны 6 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан Хэлэлцээрийн 10 дугаар зүйлийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тарифыг нэгдүгээр, айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг хоёрдугаар, тоолуургүй ахуйн хэрэглэгчдийн цахилгааны төлбөр тооцох сарын дундаж цахилгааны хэрэглээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам” /Д.Жигжиднямаа/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.АМАРСАНАА

Эрчим хүчний зохицуулах хорооны
2019 оны 119 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

**МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ”-ЫН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН
НЭГЖ БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ**

1.Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагад борлуулах цахилгааны тарифыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр		
	<i>Үүнд: Нүүрс олборлолт, боловсруулалт</i>		
	<i>Газрын тос, шатдаг хий олборлолт, боловсруулалт</i>		
	<i>Төмрийн хүдэр олборлолт, боловсруулалт</i>		
	<i>Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт</i>		
	<i>Бусад ашигт малтмал олборлолт, боловсруулалт</i>		
1.1	Энгийн тоолууртай	Төг/кВт.ц	171.49
1.2	3 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	171.49
б	Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	303.60
в	Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	84.81
2	Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага		
2.1	Энгийн тоолууртай	Төг/кВт.ц	154.65
2.2	3 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	154.65
б	Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	244.08
в	Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	98.11
3	Улаанбаатар хот, аймгийн төвийн нийтийн зориулалттай зам талбайн гэрэлтүүлэг болон нийтийн зориулалттай орон сууцны орцны гэрэлтүүлэг		
3.1	10, 11, 12, 1, 2, 3 дугаар саруудад		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 19.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	154.65
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 19.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	98.11
3.2	4, 5, 6, 7, 8, 9 дүгээр саруудад		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 22.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	154.65
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	98.11

Тайлбар: Өдөр, орой, шөнийн тарифыг мөрдөх хугацааг тоолуурын цагаар тооцно.

Эрчим хүчний зохицуулах хорооны
2019 оны 119 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

**МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ”-ЫН АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ
ТАРИФ**

1.Айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	<i>Энгийн тоолууртай</i>		
а	Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц хүртэлх хэрэглээг	Төг/кВт.ц	121.54
б	Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц болон түүнээс дээших хэрэглээг	Төг/кВт.ц	143.32
2	<i>2 тарифт тоолууртай</i>		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас шөнийн 21.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	128.03
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	98.11
3	<i>Сарын суурь тариф</i>	Төг/сар	2,200.00

Тайлбар: Өдөр, орой, шөнийн тарифыг мөрдөх хугацааг тоолуурын цагаар тооцно.

Эрчим хүчний зохицуулах хорооны
2019 оны 119 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

**МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ”-ЫН АХУЙН ТООЛУУРГҮЙ ЦАХИЛГААН
ХЭРЭГЛЭГЧДИЙН ТӨЛБӨР ТООЦОХ САРЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ**

1.Ахуйн тоолуургүй цахилгаан хэрэглэгчдийн төлбөр тооцох сарын дундаж хэрэглээг төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Сарын хэрэглээ
1	Айл өрх	кВт.ц	350